


Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын  
2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн  
02-44 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт  
155



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Авто тээврийн хяналтын улсын байцаагч

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Өдрийн 8 цаг, долоо хоногт 40 цаг

Дархан-Уул аймаг, Дархан сум, 14-р баг, Нутгийн удирдлагын ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Авто тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилэн сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Авто тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, чиг үүргийн хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх, ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг хийх, тайлагнах;
- 2.Авто тээврийн салбарын норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх;
- 3.Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Зам, тээврийн хөгжлийн яамны баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлэх, тайлагнах.	Хяналт шалгалтыг орон нутагт хэрэгжүүлсэн байна.	Г
	2.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;	Хяналт шалгалтын үр дүн дээшилж, эрх зүйн орчин сайжирсан байна	Г
	3.Хариуцсан хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудсыг боловсронгуй болгох санал өгөх, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын мэдээллийг цахим системд бүртгэх, хэрэглэгчийн хяналтын хуудсыг сурталчлах;	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Г, Х
	4.Хариуцсан хяналтын чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн хэрэглээ, үйлчилгээний соёл, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх, иргэд, бизнес эрхлэгчдийг мэдээлэл, зөвлөмжөөр хангах;	Аж ахуйн нэгж байгууллагын хуулийн сахин мөрдөлт сайжирсан байна.	Г, Х
	5.Цаг үеийн шинжтэй болон онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу ажиллах;	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г



	6. Шаардлагатай тохиолдолд хариуцсан хяналтын чиглэлээр аймгийн авто тээврийн төвийн улсын байцаагчийн хяналт шалгалтын баримт бичиг, албан бичгийг хянах, зохих стандартыг мөрдүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх, сургаж мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах.	Стандартын шаардлага хангасан байна.	Г, Х
	7. Аймгийн удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Хяналт шалгалт бүрэн гүйцэд хийгдсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1. Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, шалгалтын ажлын хэсэгт орж ажиллах, хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх.	Хяналт шалгалт бүрэн гүйцэд хийгдсэн байна.	Г, Х
	2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
	3. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
	4. Хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г
	5. Улсын байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г
	6. Шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргах;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г



	7.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль журмын дагуу хэрэгжүүлэх;	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, журмын дагуу явуулсан байна.	Г, Ш
	8.Хяналт шалгалтын чиглэлд хамааралтай зорилт, арга хэмжээний биелэлтийг аймгийн автотээврийн төвийн улсын байцаагч нараас гаргуулан авч хянах, нэгтгэх, танилцуулах;	Хэрэгжилтийг хангасан байна.	Г,Х
	9.Холбогдох чиглэлийн асуудлаар ажлын хэсэг, комисс, тендерийн болон стандартчиллын техникийн хороо зэрэгт ажиллах;	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
	10.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, шийдвэрлэх;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г,Х,Ш
	11.Байгууллагын үйл ажиллагааны болон хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах;	Олон нийтэд сурталчилсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулж, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, тайлагнах;	Хэрэгжилтийг хангасан байна.	Г
	2.Холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах;	Хамтын ажиллагаа өргөжсөн байна	Г
	3.Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн хувийн ашиг сонирхлыг зохицуулах , ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна.	Г
	4.Байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах;	Хэрэгжилтийг хангасан байна.	Г



5.Архив албан хэрэг хөтлөлтийн хууль, заавар, журам, стандартыг мөрдөж, ХХНЖ-ын дагуу албан хэргээ хөтлөх;	Хууль журам стандартыг дагаж мөрдсөн байна.	Г
6.Авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчилгүй ажиллах;	Зөрчилгүй ажилласан байна.	Г
7.Байгууллага, нэгжээс зохион байгуулсан олон нийтийн ажил, ажлын хэсэг, сургалт, мэдээллийн ажилд бүрэн хамрагдах.	Бүрэн оролцсон байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- авто инженерчлэл /071601/;</li> <li>- авто машины ашиглалт, авто аж ахуй /071602/;</li> <li>-механик инженерчлэл /071501/;</li> <li>- машин механизмын ашиглалт /071504/;</li> <li>- авто хөдөлгүүрийн механик инженержлэл /071504/.</li> </ul>	
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж, төгссөн байх	
Туршлага	Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоол гарахаас өмнө туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Хяналтын цахим систем дэх хяналт шалгалтын мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах;</li> <li>- хяналтын объектуудад эрсдэлийн үнэлгээний дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;</li> <li>- хариуцсан хяналтын салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;</li> <li>- хариуцсан хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;</li> <li>- бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах;</li> <li>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> </ul> <p>бусад.</p>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- тулгамдаж буй асуудлыг судлах, удирдлагад танилцуулах;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах;</li> </ul>


		<ul style="list-style-type: none"> <li>- хяналт шалгалтыг хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлж, шийдвэрийн төсөлд тусгах;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> </ul> <p>- бусад.</p>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх;</li> <li>- бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачилгыг дэмждэг байх;</li> <li>- аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх;</li> <li>- аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> </ul> <p>бусад.</p>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олонтой соёлч боловсон, хүндэтгэлтэй харилцах, зохих мэдээлэл, зөвлөмж өгөх;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</li> <li>- мэдээллийн технологийг албан ажилдаа бүтээлчээр хэрэглэх;</li> <li>- албан бичгийг төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулах ур чадвартай байх;</li> <li>- ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашигладаг байх;</li> </ul> <p>бусад.</p>


#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- Зам, тээврийн хөгжлийн яам
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;
- Аймгийн Засаг дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, нэгжийн дарга болон холбогдох албан тушаалтан;
- Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, төсөвт байгууллагын дарга болон холбогдох албан тушаалтан;
- Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга;



- Төрийн болон төрийн бус байгууллага, ААНБ;
- Иргэн, хуулийн этгээд.

### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ХӨЛТСИЙН ДАРГА

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 24.04.17

20... оны ... сарын ... ны өдөр

Дугаар: 145

Байгууллагын нэр:

Завхан-Уул АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2024.09.11

Дугаар: 02-А/155

(тамга/ тэмдэг)

ДАРГА

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 09 сарын 11-ны өдөр

